**НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 15 өдөр Дугаар А/39 Улаанбаатар хот

Албан хаагчдын ажлын цагт
зохицуулалт хийх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай” 209 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 03/6869 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 06.00 цагаас шилжүүлсэнтэй холбогдуулан Коронавируст /Covid-19/ цар тахлын халдвар, томуу, томуу төст өвчний өвчлөл, тархалтаас урьдчилан сэргийлэх, бага насны хүүхэдтэй эхчүүдийн хүүхэддээ тавих анхаарал, халамжийг нэмэгдүүлэх зорилгоор 0-2 хүртэлх насны хүүхэдтэй албан хаагчдын ажлын цагт зохицуулалт хийж, хорогдуулсан цагаар ажиллуулсугай.

2. Хорогдуулсан цагаар ажиллах албан хаагчдын ажлын цагийг 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд 09.00-16.30 цаг болгож, нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Тушаалын үйлчлэлд хамрагдах албан хаагчдын цалинг бүтэн цагаар ажилласанд тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн хэлтэс /Г.Гантүшиг/-т даалгасугай.

ДАРГА С.НЯМДОРЖ

ХТҮ2791 5131448
1119287925

1150500077

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн
газрын даргын 2020 оны 12 сарын
15 өдрийн А/139 дугаар тушаалын хавсралт

ХТҮ2791 5131443
1119787925

Хорогдуулсан цагаар ажиллах албан хаагчдын нэрсийн жагсаалт

| № | Албан тушаал, нэр | Харьяалах нэгж |
|---|---|---|
| 1 | Ахлах мэргэжилтэн Т.Аззаяа | Сургалт судалгааны хэлтэс |
| 2 | Нийтлэг үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Х.Орхончимэг | Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс |
| 3 | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн Н.Одонтуяа | Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс |
| 4 | Хөдөлмөрийн харилцаа, зорилтот бүлгийн асуудал хариуцсан мэргэжилтэн Х.Халиунаа | Сургалт судалгааны хэлтэс |

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР